

# АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/эхний 2-р сарын байдлаар/

**I. ТӨСӨВ:** 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 6.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 5.8 хувиар биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 5.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 50.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2012 оны жилийн эцсээс 3.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 26.4 тэрбум төгрөг болсон нь 2012 оны жилийн эцсээс 1.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Малын онд оролт: Энэ онд 2280.6 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 2 сард оны эхний малын 0.31 хувь болох 7.2 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.66 хувьтай байна.

Нийт хорогдсон малын 49.5 хувь нь ямаа, 40.7 хувь нь хонь байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Дарьганга, Мөнххаан, Асгат, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдын оны эхний малын 0.2-1.7 хувь болох 6.3 мянган мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 88 гаруй хувийг эзэлж байна.

Халзан сум мал хорогдоогүй гэж мэдээлсэн байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5.0 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.6 тэрбум төгрөгөөр доогуур, оны үнээр 14.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 5.0 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хиам, дулаан, том дээл, хантааз, пийшин, шургуулга, түлээний авдар, лааз, угаалтуур, түмпэн, хаалганы үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна. Энэ сард ууж, том болон хүүхдийн хүрэм, баривч, өлгий, даалин үйлдвэрлэлт шинээр нэмэгдсэн байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс оны эхний 2 сард 0,5 хувиар өссөнд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 0,3 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0,2 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0,5 хувиар өссөн нь нөлөөлжээ.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** Эхний 2 сард 172 эх амаржиж, 174 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна. Халдварт өвчнөөр 304 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 190-ээр өссөний дотор гахай хавдар, салхин цэцэг, тэмбүү, трихоминиаз, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 835 болж урьд оны мөн үеэс 57-н хүнээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 74,5 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 24.4 хувь нь дээд, 3 хувь нь тусгай дунд, 41,3 хувь нь бүрэн дунд, 5,4 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 2 сард 83 хүн шинээр бүртгүүлж, 24 хүн ажилд орсны дотор 21 нь шинэ ажлын байр байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** Эхний 2 сард 53 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 18 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 9.9 сая төгрөгийн хохирол учирсны 3.5 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 39 хүн холбогдон сэжиглэгдсэний 35.8 хувь нь согтуугаар, 10.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна. Нийт 472 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 40 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС